



“ХҮНС ХАНГАМЖ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРОЛ

**УРГАМЛЫН ТОС НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: 2019 ОНЫ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙН УРГАМЛЫН ТОС НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕР

ТШ КОД: ХХТ/201912004

Улаанбаатар
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хүнс Хангамж Төв ОНӨААТҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ХХТ/201912004 дугаар Ургамлын тос нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2019 оны 03 дугаар сарын 11-ны 15цаг 30 минутаас өмнө <https://tender.gov.mn> хялбаршуулсан цахим хэлбэрээр цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019.03.11**-ны өдрийн 16 цагт -т нээнэ. Tender.gov.mn цахим системээр онлайн хэлбэрээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар хот, БГД, 20-р хороо, Фүжи алтай-ий байр, 3 давхар,
Утас:, 91906868, 93200360,**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал; /Тендерт оролцогч нь үнийн саналыг маягтын дагуу бөглөж ирүүлэх
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар
 - (г) Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /Нотариатаар баталгаажуулсан.
 - (д) Тендерийн бичгийн гэрээний ерөнхий нөхцөлийн дугаар заалтанд заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа эсэх талаар мэдүүлэг
 - (е) Татварын байгууллага болон шүүхийн байгууллагын тодорхойлолт авахад татгалзах зүйл үгүй гэсэн албан тоот ирүүлэх
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Гэрээний нэр: Сонгино хайрхан дүүргийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах</p> <p>Тендерийн дугаар 2019/12004</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, БГД, 20-р хороо, Фүжи алтай байр, 3 давхар, Утас:93200360,91906868</p> <p>Огноо: 2019 оны 03 дүгээр сарын 11-ны өдөр]</p> <p>Цаг:15 цаг 30 минут</p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: : Монгол улс, Улаанбаатар хот, БГД, 20-р хороо, Фүжи алтай байр, 3 давхар, Утас: 93200360, 90061818,</p> <p>Огноо: 2019 оны 03 дүгээр сарын 11-ны өдөр</p> <p>Цаг: 16 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 3.1	<p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал; /Тендерт оролцогч нь үнийн саналыг маягтын дагуу бөглөж ирүүлэх 2. Бараа бүтээгдэхүүний үнийн болон нийлүүлэлтийн хуваарь 3. Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагын мэдээлэл ирүүлэх 4. Татвар болон шүүхийн тодорхойлолт 5. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /Нотариатаар баталгаажуулсан. 6.Тендерийн бичгийн гэрээний ерөнхий нөхцөлийн 5, 6 дугаар заалтад заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа эсэх талаар мэдүүлэг 7. Татварын байгууллага болон шүүхийн байгууллагын тодорхойлолт авахад татгалзах зүйл үгүй гэсэн албан тоот ирүүлэх 8. Санал болгож буй бүтээгдэхүүнд хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг 9. МУ-ын хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9.5-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хэрэгжүүлсэн байх, түүнийг батлах баримт бичиг ирүүлэх.
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий бараанаас бүрдэнэ:</p> <p>2019/12004 Ургамлын тос</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны тодорхойлолт: Монгол Улсын “Хүнсний тухай хууль”, “ Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн заалтыг хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх. Монгол Улсын олон Олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах шаардлагатай хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс импортлон авах ба экспортлогч улсын үйлдвэртэй шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай худалдааны гэрээ байгуулсан байх, тухайн гэрээт нийлүүлэгч нь стандарт техникийн зориулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байх ёстой. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч нь эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх, дагалдах шинжилгээний бичгүүдийг нийлүүлэлт тухай бүрд тогтмол өгч байх шаардлагатай.

2019/12004 Ургамлын тос					
№	дугаар	нэр	Бүтээгдэхүүний нэр төрөл	Техникийн тодорхойлолт болон стандарт	Сав баглаа боодол
1	2019/12004	Ургамлын тосны багц	Ургамлын тос	MNS 4-95	Зориулалтын савалгаатай 1л тэй

Баглаа, боодол: Нийлүүлэгч нь бүтээгдэхүүнийг зориулалтын уутанд савлаж, дараах мэдээллийг агуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:

- Үйлдвэрлэгчийн нэр
- Бүтээгдэхүүний нэр, төрөл
- Цэвэр жин
- Үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа
- Стандартын дагуу
- Хэрэглэх аргын заавар

Бүтээгдэхүүнийн тээвэрлэхдээ ус чийг, шороо тоосноос хамгаалсан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөр мөрдөн тогтоох бүртгэлийн хуудас
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна.
4. Төлбөр (ГЕН – 7) **4Урьдчилгаа төлбөр:** Урьдчилгаа төлбөр олгохгүй.
- 1Барааг хүлээн авахад төлөх төлбөр:** Захиалагч бараа нийлүүлэлтийн хуваарьт заасны дагуу барааг хүлээн авсан тухай бүр бараа хүлээн авсан актыг үндэслэн 90 хоногийн дотор тухайн хүлээн авсан барааны төлбөрийг төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² Алданги оногдуулах хувь:
Алдангийн нийт дүн:

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг		Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа				Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
						Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Бараа нийлүүлэх хуваарь	Бараа нийлүүлэх хэмжээ	
						(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)				
1	2	3		4	5	6	7	8	9	10
2019/12004 Ургамлын тос	1л савалгаатай	Барааны нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын агуулах	2019.04.01	2019.12.29	Сард захиалгын дагуу 1-2 удаа	Бараа нийлүүлэх хэмжээ	
		Ургамлын тос	12000						ш	